

ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
2019 ОНЫ 3 ДУГААР САРЫН ТОВЧ МЭДЭЭ

1. Удирдлага, зохион байгуулалтын талаар

Монгол улсын Засгийн газраас 2019 оныг “Иргэн төвтэй төрийн үйлчилгээ”-ний жил болгон зарласантай холбогдуулан 2019 онд хийх ажлын төлөвлөгөөг боловсруулан аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэн тухайн жилийн ажлыг зохион байгуулж, хяналт тавих үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан жилийн ажлын төлөвлөгөөг батлан төрийн байгууллагуудад хүргүүлэн ажиллаж байна. Дээрх ажлын хүрээнд аймгийн хэмжээнд төрийн болон төрийн чиг үүрэг хэрэгжүүлэгч байгууллагын ажилтан, албан хаагчдыг хамруулан “Иргэн төвтэй төрийн үйлчилгээ” аймгийн зөвлөгөөнийг зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна.

Аймгийн төрийн байгууллагуудад чанарын удирдлагын тогтолцооны стандарт нэвтрүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын захирамжаар тус ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг байгуулан төрийн байгууллагуудад төрийн үйлчилгээний соёл, хүртээмжийг нэмэгдүүлэх, төрийн албан хаагчдын бүтээмжийг дээшлүүлэх чиглэлээр сургалтыг зохион байгуулж эхлээд байна. Мөн аймгийн хэмжээнд төрийн байгууллагуудаас зөвшөөрөл, эрх, гэрчилгээ олгох зэрэг үйлчилгээг үзүүлэхэд ямар нэг шаардлагагүй төлбөр хураамж авч байгаа эсэхийг судлан үйлчилгээний шат дамжлагыг аль болох багасгах, төлбөр хураамжаас чөлөөлөх, бууруулах зорилгоор дээрх чиглэлийн үйлчилгээний судалгааг байгууллага тус бүрээр судлан нэгтгэн гаргаж байна.

Аймгийн хэмжээнд төрийн байгууллагууд “Нээлттэй хаалганы өдөр”-ийг зохион байгуулах хуваарийг гарган төрийн болон төрийн чиг үүрэг бүхий байгууллагуудад хүргүүлэн хэрэгжилтэнд хяналт тавьж ирлээ. Төрийн болон төрийн чиг үүргийг хэрэгжүүлэгч 4 байгууллага “Нээлттэй хаалганы өдөр”-ийг зохион байгуулж, төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж иргэдээс давхардсан тоогоор нийт 16 санал хүсэлт гаргасныг шийдвэрлэн хариу өгч, 100-аад иргэнд мэдээлэл зөвлөгөө өгсөн.

Иргэдийн санал хүсэлтийг төрийн бодлого шийдвэрт тусган хэрэгжүүлэх, аймгийн 2018 оны ажлын тайлан тавих болон 2019 онд хийх ажлын талаар иргэд, төрийн албан хаагчдад мэдээлэл өгөх зорилгоор 2019 оны 1, 3-р сард бүх төрийн байгууллагуудын удирдлагыг оролцуулан багуудын нутаг дэвсгэр дээр очиж иргэдтэй 13 цэгт, төрийн болон орон нутгийн өмчит байгууллагуудын ажиллагсадтай 5 цэгт нийт 18 удаагийн уулзалтыг тус тус зохион байгууллаа. Уулзалтанд 2500 гаруй

иргэн, 900 гаруй төрийн албан хаагч оролцон давхардсан тоогоор 928 санал хүсэлт гаргасныг хүлээн авч газар дээр нь шийдвэрлэх боломжтой 90 гаруй асуудлыг тухайн үед нь шийдвэрлэж, иргэдтэй уулзах үеэр гарсан санал шүүмжлэлийн мөрөөр хийх ажлын нийт 48 заалт бүхий төлөвлөгөө боловсруулан аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулж хэрэгжүүлэх арга хэмжээг авч байна.

Мөн 2019 оны 4-р сард “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын ажилчидтай уулзалт хийхээр бэлтгэл ажлыг хангаад байна. Аймгийн Засаг дарга иргэдтэй уулзалт хийх үеэр Нийгмийн даатгалын хэлтэс, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтэс, Монгол шуудан зэрэг байгууллагууд иргэдэд үйл ажиллагаагаа сурталчлах, мэдээлэл зөвлөгөө өгөх, гарын авлага материал тараах үйлчилгээг үзүүлж, орон нутагт хийсэн бүтээн байгуулалтын ажлын талаарх мэдээлэл бүхий сонинг хэвлүүлэн уулзалтанд оролцсон иргэдэд хүргүүлээ.

Аймгийн хэмжээнд иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлт, түүний мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний байдалтай сумдын ЗДТГ болон 23 төрийн байгууллагад очиж танилцан хяналт шинжилгээ үнэлгээ хийж, дүнг аймгийн Засаг даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр бэлтгэж байна. Мөн төрийн байгууллагууд төрийн үйлчилгээний соёл, хүртээмжийг дээшлүүлэх, иргэдээс гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар хэрэгжүүлж буй арга хэмжээний талаарх мэдээллийг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулах хуваарийг гарган 1-р улиралд 2 байгууллагын танилцуулгыг сонсгохоор бэлтгэлээ.

Аймгийн Засаг даргын Тамгын газарт “Иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах”-70353511 дугаарын утсыг Нэг цонхны үйлчилгээний төвд ажиллуулан тус төвд биечлэн, цахимаар болон утсаар 24 цагийн туршид иргэдийн өргөдөл гомдлыг хүлээн авч шийдвэрлэж байна. Тайлангийн хугацаанд тус төвд нийт 577 өргөдөл, гомдол ирснээс 574 нь буюу 99,5 хувь нь хуулинд заасан хугацаанд шийдвэрлэгдсэн, 3 нь шийдвэрлэх хугацаа болоогүй байна. Ирсэн өргөдөл гомдлын 46 нь гомдол, 6 нь санал, 63 нь талархал, 462 нь хүсэлт байна. Тус төвд ирж буй өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар 7 хоног тутамд аймгийн Засаг даргын шуурхай зөвлөгөөнд танилцуулан холбогдох албан тушаалтанд үүрэг даалгаврыг өгч, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Аймгийн Засаг дарга иргэдийг 7 хоног тутамд тогтмол хүлээн авч уулзан тэдний санал, хүсэлтийг шийдвэрлэж ирсэн ба тайлант хугацаанд нийт 170 иргэнийг биечлэн хүлээн авч уулзан санал, хүсэлтийг нь шийдвэрлэлээ.

Эхний улирлын байдлаар аймаг, сумдын Засаг даргын Тамгын газар болон хэлтэс, албадууд, төрийн чиг үүрэг бүхий байгууллага, ажилтанд нийт 3920 өргөдөл, гомдол ирсний 164 нь шийдвэрлэх хугацаа болоогүй, 3756 буюу 95,8 хувь нь хуулинд заагдсан хугацаанд шийдвэрлэгдлээ.

Япон улсаас Монгол улсад суугаа Элчин сайд Масато Такаока манай аймагт айлчлал хийж, Японы Засгийн газрын “Өвсний үндэс” хөтөлбөрийн буцалтгүй тусламжаар цас цэвэрлэх олон үйлдэлт машины тээвэрлэлтийн зардлыг олгох гэрээнд гарын үсэг зурсаны зэрэгцээ Жайка олон улсын байгууллагын шугамаар манай аймагт ажиллаж буй сайн дурын ажилтнуудтай уулзаж, Медипас эмнэлэг, 15 дугаар цэцэрлэгийн үйл ажиллагаатай танилцлаа.

2. Эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд

3-р сарын байдлаар аймгийн төсөвт 26.2 тэрбум төгрөгийн орлогыг төвлөрүүлж, төсвийн гүйцэтгэл 116.5 хувьтай байна. Татварын орлогын төлөвлөгөө 32.2 хувиар давж, татварын бус орлогын төлөвлөгөө 1.7 хувиар тасарчээ. Орон нутгийн төсвөөс төлөвлөгөөт санхүүжилтийн 52.8 хувь буюу 17.2 тэрбум төгрөгийн зарлага санхүүжилт хийсний 5.9 хувийг нийгмийн даатгалын шимтгэлд, 7.6 хувийг хөрөнгийн зардалд, 11.8 хувийг татаас ба урсгал шилжүүлэгт, 28.0 хувийг бараа үйлчилгээний зардалд, 46.7 хувийг цалин хөлсөнд зарцуулжээ. Өмнөх оны мөн үеэс нийт зарлага санхүүжилт 13.1 хувиар, орлого 17.4 хувиар их байна.

3. Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд

Аймгийн Цагдаагийн газрын мэдээгээр 181 хэрэгт 83 хүн холбогдон шалгагдаж, хэргийн илрүүлэлт 42.0 хувьтай байна. Өмнөх оны мөн үеэс бүртгэгдсэн хэрэг 27.6 хувиар, холбогдогч 21.0 хувиар, 18–аас дээш насны 10000 хүнд ногдох гэмт хэрэг 10.3 процицимилээр буурч, хэргийн илрүүлэлт 20.9 пунктээр их байна. Нийт бүртгэгдсэн хэргийн 24.3 хувь нь согтуугаар үйлдэгдсэн хэрэг, 30.9 хувь нь хүнд гэмт хэрэг, 93.4 хувь нь хэрэг бүртгэлтийн хэрэг байгаа ба өмнөх оны мөн үеэс хэрэг бүртгэлтийн хэрэг 8.6 хувиар, хүнд гэмт хэрэг 27.3 хувиар буурчээ. Өмнөх оны мөн үеэс хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг болон хулгайлах, дээрэмдэх хэргүүд 40.8-85.7 хувиар буурч, бусад хэргийн гаралт 3.6-80.0 хувиар нэмэгдсэнээс хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг хэрэг 80.0 хувиар нэмэгджээ. Гэмт хэргийн улмаас иргэд, байгууллага, аж ахуйн нэгжид 848.0 сая төгрөгийн хохирол учирч, нийт хохирлын 12.9 хувийг нь нөхөн төлүүлсэн байна.

Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодон замын хөдөлгөөнд оролцож байсан 360 жолоочийг илрүүлж, зөрчил гаргасан 304 жолоочийн эрхийг тодорхой хугацаагаар хасч шийтгэжээ. Өмнөх оны мөн үеэс согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодон замын хөдөлгөөнд оролцсон жолоочийн тоо 16.9 хувиар, эрх хасалт 7.6 хувиар буурсан байна.

4. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд

Боловсролын чиглэлээр:

Боловсролын үнэлгээний төвөөс Монгол хэл бичгийн шалгалтыг зохион байгуулж 632 сурагч, иргэд хамрагдсан байна.

“Багш” дэд хөтөлбөрийн хүрээнд аймгийн ЗДТГ, Боловсрол, соёл урлагийн газар, Боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэгтэй хамтран 1-5 дахь жилдээ ажиллаж байгаа багш нараас 100 багшийг сонгож “БИ ЗАЛУУ БАГШ- II” модуль сургалтын 1-р шатыг эхлүүлэв.

“Хүүхдэд ээлтэй багш” сэдэвт чадавхжуулах сургалтыг Япон улсын зөвлөх багштай хамтран “Тусгай хөтөлбөр”-ийн танилцуулга хийж, зөв хандлагатай, зөв иргэнийг хөгжүүлэх, хөтөлбөрийн бусад хичээлүүдийн уялдаа холбоо, заах арга зүй сэдвүүдээр зохион байгуулж нийт 281 багш, оюутнуудыг хамруулсан.

Эрүүл мэндийн чиглэлээр:

Эрүүл мэндийн байгууллагууд давхардсан тоогоор 154.9 мянган хүнд үзлэг хийснээс 35.9 хувийг нь урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан. Өмнөх оны мөн үеэс нийт үзлэг 2.7 хувиар, урьдчилан сэргийлэх үзлэг 3.5 хувиар нэмэгджээ. Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд давхардсан тоогоор 31.1 мянган иргэнд үйлчилсэн ба өмнөх оны мөн үеэс үйлчлүүлэгсдийн тоо 27.1 хувиар нэмэгдсэн байна.

Эрүүл мэндийн газрын мэдээгээр аймгийн хэмжээнд 623 эх амаржин эхийн эндэгдэлгүй ажиллав.

Эрүүл мэндийн салбарын удирдах ажилтнуудын дунд “Инээмсэглэл эерэг хандлага-Эрүүл Эрдэнэт” зөвлөгөөн боллоо. Зөвлөгөөнд ЭМЯ-ны төрийн нарийн бичгийн дарга, холбогдох мэргэжилтэн, эрүүл мэндийн салбарын удирдлагууд, эмч, эмнэлгийн мэргэжилтэн нийт 150 гаруй төлөөлөл оролцсон.

ХӨСҮТ-ээс Нийгмийн эрүүл мэндийн төвтэй хамтран сургалт зохион байгууллаа. Үүнд: “Вируст гепатитийн урьдчилан сэргийлэлт, илрүүлэг оношлогоо, эмчилгээний чадавхи сайжруулах”, “Дархлаажуулалт, тууралтат халдварт өвчнүүдийн ялган оношлогоо”, “Хүүхдийн сүрьеэгийн оношлогоо эмчилгээний ур

чадварыг сайжруулах нь”, “Шинэ вакцин дархлаажуулалтад нэвтрүүлэх нь” сэдэвт сургалтуудад 200 гаруй эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан.

Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын чиглэлээр:

Эхний улирлын байдлаар нийт 461 ажлын байр бий болсны 40.3 хувь нь шинээр бий болжээ. Ажлын байраар хангагдагсдын 21.9 хувь нь үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбарт, 21.3 хувь нь боловсруулах үйлдвэрлэлийн салбарт, 11.7 хувь нь зочид буудал, зоогийн газарт, 7.8 хувь нь худалдааны салбарт, 6.7 хувь нь боловсролын салбарт ажиллаж байна. Шинээр бий болсон ажлын байрны 24.7 хувь нь боловсруулах үйлдвэрлэлийн салбарт, 18.3 хувь нь худалдааны салбарт бий болжээ.

3 сарын байдлаар 372 хүн шилжин ирсэн ба үүний 32.5 хувь нь Улаанбаатар хотоос, 24.2 хувь нь Булган аймгаас, 8.9 хувь нь Сэлэнгэ аймгаас шилжин ирсэн нь дийлэнх хувийг эзэлж байна.

Аймгийн дүнгээр давхардсан тоогоор 40.1 мянган хүнд 26.3 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж, хөнгөлөлт олгосноос 1.9 мянган хүнд 763.0 сая төгрөгийн халамжийн тэтгэвэр, 1.7 мянган хүнд 241.1 сая төгрөгийн нөхцөлт мөнгөн тэтгэмж, нийгмийн дэмжлэг туслалцаа шаардлагатай 1.3 мянган хүнд 186.1 сая төгрөгийн хөнгөлөлт, нөхцөлт мөнгөн тусламж, 5.0 мянган ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд 137.4 сая төгрөгийн тусламж, хөнгөлөлт, хүн амын хөгжлийг дэмжих чиглэлийн улсын төсвийн санхүүжилтээр 16.1 мянган хүнд 1.9 тэрбум төгрөгийн тэтгэмж, тусламж, хөнгөлөлт олгожээ.

Нийгмийн даатгалын сангийн орлогод 23.3 тэрбум төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөө 129.7 хувиар, сангуудын орлогын төлөвлөгөө 20.9-42.7 хувиар давж биелжээ. Сангийн нийт орлого өмнөх оны мөн үеэс 21.8 хувиар их байна.

Зорилтот өрхийн хөгжил хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөрийн хүрээнд Баян-Өндөр сумын ЗДТГ-тай хамтран “Тохилог хашаа тохилог орчин” аяны 2-р шатны ажлыг эхлүүлж, өөрийн эзэмшлийн газар, хашаагүй 10 өрхөд газар өгч, хашаа барихад 10.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж гэрчилгээг гардуулан өгсөн.

Иргэдээс ирүүлсэн өргөдлийн дагуу хорт хавдар болон байнгын эмчилгээ хийлгэх шаардлагатай хүнд өвчтэй 95 хүнд 14.4 сая төгрөг олгож, орон гэр хүссэн иргэдэд гэр олгох зорилгоор орон нутгийн төсөвт 220,0 сая төгрөгийг тусган гэр худалдан авах тендерийг нээлттэй зарлаад байна.

Соёл, спортын чиглэлээр:

2019 оны 3 дугаар сарын 21-ний өдөр Боловсрол, соёл урлагийн газар, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, “Шүүдэр” охидын төв хамтран “Охид- гэрэлт

ирээдүй” охидын чуулганыг амжилттай зохион байгууллаа. Чуулганд 6-12-р ангийн 150 охид, 60 эцэг эх, 40 анги удирдсан багш, нийгмийн ажилтан, хүүхэд хөгжил төлөвшлийн ажилтнууд, Эрдэнэт “Сороптимист” ТББ-ын төлөөллүүд, “Сэтгэлийн-Анир” төслийн баг хамт олон зэрэг 300 гаруй хүн оролцож, чуулганаас зөвлөмж гаргасан байна.

Орхон аймгийн Засаг даргын нэрэмжит Самбо бөхийн 2019 оны залуучуудын улсын аварга шалгаруулах эрэгтэйчүүдийн 35, эмэгтэйчүүдийн 28 дахь удаагийн тэмцээнийг Хангарьд паласт амжилттай зохион байгуулж нийт 22 байгууллагын 250 гаруй тамирчид оролцож 2 мөнгө, 1 хүрэл медаль хүртсэн.

Хүүхдийн спортын VI их наадмын хүрээнд сагсан бөмбөгийн аймгийн аварга шалгаруулах тэмцээн, 100 буудалт даамны өсвөр үеийн аварга шалгаруулах тэмцээн, таеквондогийн өсвөр үеийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнүүдийг зохион байгуулж 450 гаруй тамирчдыг хамруулав.

5. Хүнс, хөдөө аж ахуйн бодлогын хүрээнд:

Аймгийн хэмжээнд 2019 онд нийт 4967 га талбайд тариалалт хийхээр төлөвлөсөн. Үүнээс үр тариа 3980 га, малын тэжээл 140 га, төмс 368 га, хүнсний ногоо 349 га, жимс, жимсгэнэ 130 га-д тариалж үр тариа 6368 тонн, малын тэжээл 280 тонн, төмс 4410 тонн, хүнсний ногоо 4184 тонн, жимс, жимсгэнэ 35 тонн ургац хураан авах, 3950 тонн уринш бэлтгэх төлөвлөгөөг сум тус бүрээр гарган ажиллаж байна. 2019 онд үр тариалах талбай, нөөцөлсөн үр, боловсруулах уринш, ургамал хамгааллын бодисын захиалгыг аж ахуйн нэгж, иргэн бүрээр гарган Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт хүргүүлэв. Захиалгын дүнгээр үр тариа 4254 га, бэлтгэх уринш 4254 га, буудайн үр 422 тонн, ургамал хамгааллын бодис 11454 литр байна. Мөн аж ахуйн нэгжүүд 583 тонн буудайн үр нөөцөлсөн.

Аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан 44 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг Баян-Өндөр, Жаргалант сумын 12 чиглэлд ажиллаж, мал бүхий өрхүүдэд төр засгийн болон орон нутгийн бодлого шийдвэрийг таниулах, нийгмийн зарим үйлчилгээ үзүүлэх, мал аж ахуйн хаваржилт, төл бойжилтийн явц байдалтай үнэлэлт дүгнэлт өгч, цаашид авах арга хэмжээний талаар санал солилцлоо.

Оны эхний төллөх эх малын 27.9 хувь буюу 15.4 мянган хээлтэгч мал төллөж, гарсан төлийн 99.9 хувь нь бойжиж байна. Өмнөх оны мөн үеэс төллөлт 22.4 пунктээр их, төлийн хорогдол 93.7 хувиар бага байна. 50 толгой том мал зүй бусаар хорогдож, мал онд оролт 99.96 хувьтай байна. Өмнөх оны мөн үеэс мал онд оролт 2.39 пунктээр их, малын хорогдол 98.3 хувиар бага байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Европын холбоо, Чехийн “Пиплин нийд” ОУБ, Монголын хуульч эмэгтэйчүүдийн холбоотой хамтран 21 аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалтыг зохион байгуулж Сум хөгжүүлэх сангийн хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр Иргэний тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, гэрээний эрх зүй, үүргийн эрх зүй, гэрээнд тусгах зүйл, гэрээний биелэлт хангуулах, гэрээний хугацаа дуусахад ямар хугацаанд шүүхэд хандах ёстой, барьцаа хөрөнгийн үнэлгээ, барьцааны гэрээг хэрхэн баталгаажуулах зэрэг хууль эрх зүйн акт, мөн зээлийн мэдээллийн санд бүртгэхтэй холбоотой программ хангамжийг ашиглах, бүртгэх, цаашид анхаарах зүйлсийн талаар мэдээллээ.

Аймгийн мал эмнэлгийн байгууллагууд 16.6 мянган толгой малд үзлэг, 0.5 мянган толгой малд туулгалт хийж, паразит өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 24.4 мянган толгой малыг хамруулсан байна. Өмнөх оны мөн үеэс үзлэгт хамруулсан мал 34.8 хувиар, туулгалт хийсэн мал 54.7 хувиар буурчээ.

Баян-Өндөр, Жаргалант сум, Мэргэжлийн хяналтын газар, Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг, Мал эмнэлгийн газартай хамтран 8 мал эмнэлгийн үйлчилгээний нэгжид төлөвлөгөөт хяналт шалгалтын ажлыг хийж гүйцэтгэлээ.

Олон улсын хэрэглэгчийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан холбогдох төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдтэй хамтран “Аюулгүй, ухаалаг бараа, бүтээгдэхүүн” сэдвийн хүрээнд өдөрлөг зохион байгууллаа. Тус арга хэмжээнд нийт 180 гаруй иргэн, аж ахуйн нэгж оролцож, “Орда заан хошуу ХХК, Идэрбаялаг ХХК, Эрдмийт ХХК, Цагаан итгэлт ХХК, Эрдэнэт өег ХХК зэрэг хүнсний үйлдвэрлэл эрхлэгчдийн бараа, бүтээгдэхүүн, үйл ажиллагааг нээлттэй сурталчилан, давс бууруулж буй бүтээгдэхүүнүүдийн үзэсгэлэн худалдааг зохион байгуулав.

6. Байгаль орчин, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн салбарын бодлогын хүрээнд:

БОАЖ-ын Сайдын 2019 оны А/41 дүгээр тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн байгаль хамгаалах, нөхөн сэргээх талаар хэрэгжүүлсэн ажлын үр дүн, усны нөөцийн ашиглалт, хаягдлын сангийн цагаан тоосыг бууруулах талаар хийсэн арга хэмжээг газар дээр нь үзэж танилцан урьдчилсан дүгнэлтийг гаргаж ажиллалаа.

Монголын хог хаягдлыг дахин боловсруулах үндэсний холбоотой хамтран Орхон, Булган аймгийн хог хаягдлын менежментийг сайжруулах чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй төрийн болон төрийн бус байгууллагуудын төлөөллүүдийг хамруулан “Дахин боловсруулах үйлвэрлэлийн түүхий эдийг бэлтгэх менежмент”

сэдэвт сургалтыг зохион байгууллаа. Сургалтаар хог хаягдлын тухай хууль, эрхзүйн мэдээлэл, хог хаягдлыг дахин боловсруулж бүтээгдэхүүн үйлдвэрлэж буй үйлдвэрүүдийн танилцуулга болон хог хаягдлыг ангилан ялгах аргазүйн талаар мэдээлэл өгч, “Монголын хог хаягдлыг дахин боловсруулах үндэсний холбооны Орхон аймаг дахь салбар хороо”-г байгуулж хамтран ажиллалаа.

“Усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд орон нутгийн оролцоог хангах нь” сэдэвт уулзалт, хэлэлцүүлгийг салбарын байгууллагууд хамтран зохион байгууллаа. Тус хэлэлцүүлэгт Орхон аймгийн ЗДТГ, Баян-Өндөр сумын ЗДТГ болон Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Ус цаг уур, орчны шинжилгээний газар, “Эрдэнэт Ус, дулаан түгээх сүлжээ” ОНӨХК, Эрдэнэт Үйлдвэр ХХК-ийн Эрчим хүчний цехийн холбогдох албан хаагчид оролцож, усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд орон нутгийн оролцоог хангах, аймгийн ус хангамжийн өнөөгийн байдал, ус хангамж, усны алдагдал, 2018 оны хур тунадасны хэмжээ, 2019 оны төлөв байдлын талаар мэдээлэл хийж, санал солилцов.

Гэр хорооллын багийн иргэдэд “Усны бохирдол, усны савны эрүүл ахуй” сэдвийн хүрээнд цуврал сургалтуудыг зохион байгууллаа.

Мөн ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах эргүүл шалгалтын ажлыг зохион байгуулж, уг ажлын хүрээнд ой хээрийн бүсэд аялал зугаалга хийж, зорчиж байсан нийт 23 тээврийн хэрэгсэл шалгаж, 85 иргэнд мэдээлэл өгч, 45 ш анхааруулга санамж тараалаа.

Байгаль цаг агаарын хувьд сарын дундаж температур -2.3 хэмийн хүйтэн байж, өмнөх оны мөн үеэс -0.5 хэмээр дулаан, хур тунадас 2.3 мм-ээр бага байна.

Аж үйлдвэрийн салбарт 527.1 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн, 538.0 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн борлуулж, өмнөх оны мөн үеэс үйлдвэрлэлт 13.5 хувиар, борлуулалт 17.1 хувиар буурсан байна. Нийт бүтээгдэхүүний 99.97 хувь нь Баян-Өндөр суманд, 0.03 хувь нь Жаргалант суманд үйлдвэрлэгджээ. Нийт бүтээгдэхүүний 92.0 хувийг уул уурхайн олборлох, 4.1 хувийг боловсруулах, 3.9 хувийг цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэлийн салбарт үйлдвэрлэжээ.

Аймгийн Үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих сангаас зээл авахаар төсөл ирүүлсэн 295.0 сая төгрөгний 7 төслийг ажлын хэсгийн хурлаар хэлэлцэн дэмжиж арилжааны банкуудад хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Оны эхний 3 сард их барилгын салбарт 5 аж ахуй нэгж 3.9 тэрбум төгрөгийн барилга угсралт, их засварын ажлыг 5 объектод хийж гүйцэтгэсний 6.7 хувь нь их засварын ажил байна. Гүйцэтгэсэн ажлын дүн өмнөх оны мөн үеэс 2.9 дахин нэмэгджээ.

Тээврийн байгууллагууд 38.0 мян/тн ачаа тээвэрлэн, 13.1 сая.тн/км-ийн ачаа эргэлт, 1.5 сая зорчигч тээвэрлэн, 26.2 сая.хүн/км-ийн зорчигч эргэлт хийж, тээврийн үйлчилгээнээс 4.6 тэрбум төгрөгийн орлоготой ажилласан байна.

Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх хуулийг хэрэгжүүлж эхэлсэн хугацаанд хүсэлт гаргасан 21.5 мянган өрхөд 1523.88 га газрыг гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өмчлүүлсэнээс 22.83 га газрыг энэ оны 1-р улиралд өмчлүүлсэн байна. Газар хүссэн өрхийн хүсэлтийн 91.1 хувийг барагдуулж, газрын төлбөрт 4.4 тэрбум төгрөгийг төвлөрүүлжээ.